

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ
4. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
11. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
12. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨГӨӨ
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨ
16. НЭГДСЭН ЗАРДАЛ
17. ХАВСРАЛТ

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Хүрэншандын чулуун нүүрсний орд ашиглах”

1.2. Төслийн зорилго

“Өсөх зоос” ХХК нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших “Хүрэншандын нүүрсний орд ашиглах” нэртэй, MV-017317 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 30 жилийн хугацаанд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөнд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

1.3. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр, хаяг

“Өсөх зоос” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011136094

Регистрийн дугаар: 5199077


Монгол улс, Улаанбаатар хот,

Баянзүрх дүүрэг, 4-р хороо 15-р хороолол, 64-32 тоот

Утас: +976 11 323203

1.4. Төслийн байршил, ерөнхий тойм зураг

Нарийн Сухайтын нүүрсний ордын Хүрэншандын хэсэг нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт, Даланзадгад хотоос баруун зүгт 296 км, Улаанбаатар хотоос баруун урагш 849 км, Гурван тэс сумын төвөөс урагш 34 км-т оршдог.



Зураг.1 Төслийн байршил

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ

Газарзүйн мужлал: Хүрэншандын нүүрсний уурхай нь Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их муж, Алтайн өвөр говийн бэлэрхэг уул, талын муж, Алтайн өвөр говийн баруун хэсгийн тал, бэлэрхэг уул бүхий хэт гандуу цөл, өмнөд цөлийн дэд муж, Хүхэлзэхийн говийн өмнөдийн цөл, хэт хуурай цөл бүсэд хамаарагдана. Газрын гадаргуу далайн түвшнээс дээш дунджаар 1545 м, хамгийн нам цэг 1463, хамгийн өндөр цэг 1640 м-т байна.

Уур амьсгал: Энэ нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө цас багатай, хүйтний эрч бага, хавар хүйтэвтэр, шороон шуурга элбэгтэй, салхины чиглэл тогтворгүй, зуны улиралд хур бороо багатай, хуурай халуун уур амьсгалтай байдаг. Жилдээ өдрийн дээд ба доод температур нь дунджаар (зуны улиралд) +45°C ба (өвлийн улиралд) -45°C хүрнэ. Ихэнх хур тунадас нь 6-аас 9-р сард ордог. Салхины чиглэл нь өвөлдөө баруун, өмнөд зүгийн салхи зундаа баруун, баруун хойд талаас үлээх ба хавар, зуны улиралд шороон шуурга ихтэй. Хавар, зундаа хүчтэй салхитай боловч намар, өвлийн улиралд салхины эрч буурдаг.

Гадаргын ус: Хүрэншандын нүүрсний ордыг ашиглах төслийн талбай нь ус зүйн мужлалтаар Төв Азийн гадагш урсацгүй ай сав, Алтай өвөр говийн сав газарт түр урсгал бүхий гол горхины мужид хамаарагддаг.

Төв Азийн гадагш урсацгүй ай савд орших гол, горхиуд Монгол орны нийт урсцын 40 орчим хувийг бүрдүүлдэг боловч Алтай өвөр говийн сав газарт гадаргын усны сүлжээ муу хөгжсөн, байнгын урсацтай гол горхи байхгүйгээс ус зүйн хувьд төдийлэн сайн судлагдаагүй, хур борооны уснаас хамааралтай тогтмол биш ундаргатай цөөнгүй тооны булаг, шанд, нуур, цөөрөм л байдаг.

Газрын доорх ус: Судалгааны талбай нь Гидрогеологийн мужаар (Газар доорх усны тэжээлийн горим) Улирлын хомс тэжээлтэй муж, Өмнөговийн дэд муж орж байна. Гидрогеологийн 1:1'000'000 зургийг иш үндэс болгон зохиосон, монгол орны гидрогеологийн дүүрэгчлэлийн зургаас харахад гидрогеологийн системийн өмнөд хэсэгт Хүхэлзэхийн говийн газрын доорх усны ай сав мөн монгол орны усны сав газрын ангиллаар Алтай өвөр говийн сав газарт орж байна. Судалгааны талбай орших район нь Хүхэлзэхийн говийн томоохон артезийн усны ай савд байрлах ба гидрогеологийн региональ судалгаа харьцангуй сайн хийгдсэн байна.

Хөрс: Уурхайн талбай нь Монгол орны хөрс - газарзүйн мужлалаар Говийн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн Говь-Алтайн хөрсний дэд бүсийн хүрээнд Алтайн чанад дахь тойрогт хамрагдана¹. Энд ихэвчлэн нам уулс, ухаа гүвээ толгодын сул хөгжилтэй чулуутай бор хөрс, цөлийн бор саарал, хээржүү цөлийн цайвар бор хөрс тус тус тархана. Механик бүрэлдэхүүний хувьд элсэн, элсэнцэр, хөнгөн шавранцар ба ялзмагийн агууламжаар бага, сул шүлтлэгээс хүчтэй шүлтлэг урвалын орчинтой, дунд зэргийн карбонаттай, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар бага зэрэг, хөрсний ерөнхий үржил шимийн түвшин бага байна.

Ургамал: Уурхайн талбай нь Алтайн өвөр, Алашаа говийн тойрогт хамаарагдана. Алтайн уулын цөлөрхөг хээрийн хил залгаа бүс нутагт хамаарагдах бөгөөд урд хэсгээрээ хэт гандуу цөлийн ургамлын хэв шинжтэй, төв болон хойд хэсгээрээ Алтайн салбар уулын Сэврэй, Эхэн, Зулганайн цөл болон цөлөрхөг хээрийн ургамалжилттай. Тус сумын уулархаг газраар хад асга ихтэй, уулын ам хөндий, бэл хормойнууд нь тал хөндийрүүгээ ортол үргэлжилсэн урт сайр жалгаас ихээхэн

¹ Үндэсний атлас, 2009 он

хэрчигдсэн учир сайр жалга дагаж харгана, хотир, буйлс зэрэг сөөг, сөөгөнцөр нилээд түгээмэл тохиолдоно.

Амьтан: Уурхайн талбай нь Монгол орны говь, цөлийн хээрийн хэсэгт хамаарах ба Төв Азийн хуурай гандуу бүс нутгийн түгээмэл шинжийг илэрхийлнэ. Монгол орны амьтны газар зүйн мужлалаар Алтайн өвөр говийн тойрогт хамаарагдана. (А.Г.Банников 1954). Цөлөрхөг хээрийн экосистем тул амьдрах орчны элдэв хэв шинж цөөн илрэх бөгөөд бүхэлдээ нэг хэвийн амьдрах орчин зонхилно. Иймд биологийн олон янз байдлын хувьд нэлээд ядмаг байдаг.

Газар ашиглалт: Гурвантэс сумын газар нутаг нийт 280219.9 га талбайтай. Үүнээс Хөдөө аж ахуйн газар 1394351.5 га буюу 49.7%, Хот тосгон бусад суурины газар 11498.8 га буюу 0.41%, Зам, шугам сүлжээний газар 4331.4 га буюу 0.15%, Ойн сан бүхий газар 269208.7 га буюу 9.6%, Улсын тусгай хэрэгцээний газар 1122284.9 га 40.1%-г тус тус эзэлж байна².

Нийгэм, эдийн засгийн байдал: Гурвантэс сум нь хойд, баруун, баруун урд талаараа Баянхонгор аймгийн Шинэжинст, Баянлиг сум, зүүн, зүүн хойд хэсгээрээ тус аймгийн Сэврэй, Ноён сум, урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эзний хошуутай хиллэдэг. Аймгийн төвөөс 320 км, засаг захиргааны анхан шатны нэгж болох 5 багтай.


Нийт 1717 өрхтэйгээс 666 нь малчин өрх, 5316 хүн амтай үүний 1056 эрэгтэй, 954 эмэгтэй. 2021 оны жилийн эцсийн байдлаар 177.103 толгой мал тоолуулсан³. Сумын хэмжээнд 7 төсөвт байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Сумын эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй, уул уурхай юм. Орон нутгийн онцлогийн хувьд байгалийн баялаг, аймаг нийслэлийг холбосон зам харилцааг даган хөгжих боломжтой.

Сумын цэцэрлэгийн 3 байранд жилдээ 300 орчим гаруй хүүхэд хүмүүжиж, 15 ортой хүн эмнэлэг, 250 суудалтай Соёлын төв, номын сан, 16 хүний бүрэлдэхүүнтэй Цагдаагийн тасаг ажиллаж байна. 2005-2006 оны хичээлийн жилээс 8 жилийн дунд сургууль 11 жилийн сургалттай сургууль болон өргөжсөн бөгөөд хичээлийн 3 байранд нийт 70 багш ажилчид ажиллаж, 1017 хүүхэд суралцаж байна. Мөн тус сумын нутагт хилийн цэргийн 0166 дугаар анги байрладагаас гадна “Шивээ хүрэн”-ийн хилийн боомт үйл ажиллагаа явуулж байна. Холбоо харилцааны хувьд мобиком, скатейл, юнител, жимобайл зэрэг үүрэн телефон суурилагдан, хүн амын 100 хувь нь гар утас хэрэглэж байна. БНХАУ-ын ӨМӨЗО-ны хөрш аймгаас өндөр хүчдэлд холбогдсон, 24 цагийн гэрэл цахилгаантай.

² Газрын нэгдмэл сангийн 2013 оны тайлан, тэнцлийн тухай

³ <http://www.1212.mn/> статистик мэдээллийн нэгдсэн сан

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ



Зураг.2 Уурхайн ашиглалтын талбайн зураглал

3.1. Төслийн хэрэгжих орчны уур амьсгалын нөхцөл

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт өвс ургамалтай, ургамалгүй гадарга, баян бүрд, булаг шанд, уул нуруу, хотгор, хөндий, тэгш тал, говь цөл хослон оршдог нь уур амьсгалын өвөрмөц нөхцөлийг бүрдүүлнэ.

Нарийн Сухайтын Хүрэн шандын нүүрсний орд орчмын нутаг дэвсгэр нь цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө цас багатай, хүйтний эрч бага, хавар хүйтэвтэр, шороон шуурга элбэгтэй, салхины чиглэл тогтворгүй, зундаа хуурай халуун уур амьсгалтай. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөл -15°C -аас -20°C хүйтэрч, зун $+30^{\circ}\text{C}$ -аас $+35^{\circ}\text{C}$ заримдаа $+40^{\circ}\text{C}$ -аас давж хална. 1 сард агаарын дундаж температур -15°C -аас -18°C , 7-р сард агаарын дундаж температур $+20^{\circ}\text{C}$ -аас $+25^{\circ}\text{C}$.

Жилийн агаарын дундаж температур $+2^{\circ}\text{C}$ -аас $+5^{\circ}\text{C}$ байна. Жилийн дунджаар авч үзвэл салхигүй өдрийн тоо 10-15 хоног.

Хамгийн их салхи хавар тохиолдох бөгөөд дунджаар 5.9 м/сек, хамгийн бага салхитай улирал нь өвөл бөгөөд салхины хурд дунджаар 4.2-4.3 м/сек ба жилийн 30-35 хоног 15 м/сек хүртэл хүчтэй цасан болон шороон шуургатай байдаг.

Агаарын температур

Гурвантэс сумын нутагт жилийн агаарын дундаж температур 5.6°C байдаг. Энэ район нь говь цөлийн ширүүн уур амьсгалтай. Өвөл нь $15-20^{\circ}\text{C}$ хүйтэн, зун, намрын саруудад маш халуун болж агаарын температур $+(3^{\circ}\text{C}-35^{\circ}\text{C})$, зарим үед $+40^{\circ}\text{C}$ хүрдэг. Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сард агаарын дундаж температур -23°C , хамгийн их халуун 8 дугаар сард агаарын дундаж температур $+30^{\circ}\text{C}$ орчим, агаарын үнэмлэхүй хамгийн их температур $+39.8^{\circ}\text{C}$, үнэмлэхүй бага температур -40°C байдаг. Гурвантэс сумын цаг уурын станцын мэдээгээр $+30^{\circ}\text{C}$ -аас халуун өдрийн тоо жилд дунджаар 31 байна.

Хур тунадас

Энд хур тунадасны уналт их биш, жилийн дундаж хур тунадас 82.4 мм, үүний 60 хувь нь зуны улиралд ордог байна. Гурвантэс сум нь уур амьсгалын нэн хуурай дулаан говь, цөлийн бүсэд багтана. Нэн хуурай дулаан говь, цөлийн бүсийн уур амьсгалын ерөнхий онцлог нь агаар, хөрсний чийгээр дутмаг байдаг. Хур тунадас маш бага унадаг, ялангуяа 1970-аад оноос хойш

тунадасны хэмжээ улам багасаж зун, намрын саруудад гандуу байдаг болсон. Өвөл цасны бүрхүүлийн зузаан 0-3 мм, зун нь хур тунадасны хэмжээ 30-60 мм, жилд дунджаар 51 мм орчим тунадас унадаг болсон байна.

Агаарын даралт

7 дугаар сарын агаарын хоногийн дундаж даралт 849.2-862 мм м.у.б., 3 дугаар сард 857.5-875.6 мм м.у.б -д хүрч харьцангуй чийгшлийн дундаж 40-49 % болдог байна.

Нарны гэрэл

Нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа жилд 2900 орчим цаг, үүнээс дулааны улиралд 1960 цаг байна. Энд үүл, хур тунадас багатай, нарны гэрлийн эрчим хүч ихтэй юм.

Салхины горим

Нарийн Сухайтын Хүрэн шандын нүүрсний орд орчмын салхины горим өвөрмөц орон нутгийн шинжтэй салхины жилийн дундаж хурд 2.0-2.7 м/сек; хамгийн их хурд 14 - 30 м/сек -д хүрдэг. Өвөлдөө баруун, өмнөд зүгийн салхи зундаа баруун, баруун хойд зүгийн салхи зонхилдог нь тус газар нутгийн геологийн тогтоцтой холбоотой. Харин 4 дүгээр сарын салхины дундаж хурд 4.0 м/с хүрдэг байна. Салхигүй үеийн давтагдал өвөл 12-1 сард 52.5-62.6% байдаг бол 4 дүгээр сард энэ нь 31.3% хүртэл буурдаг. Энэ сард өдрийн 13 цагийн салхигүй үеийн давтагдал дөнгөж 9.6% байна. Иймд хаврын улиралд өдрийн цагт их төлөв салхитай байдаг бөгөөд 13 цагийн салхины дундаж хурд 4 дүгээр сард 4 м/сек орчим байна. 4, 5 дугаар саруудад хүчтэй салхи 10-15 удаа тохиолдоно. Жилд дунджаар 25 өдөр шороон шуургатай байдаг. 4, 5 дугаар саруудад 3-4 удаа шороон шуурга болдог.

Хөрсний гадаргын температур

Энэ нутагт хөрсний гадаргын жилийн дундаж температур 9.2°C, дулааны улиралд хөрсний гадаргын температур дунджаар +25°C байдаг бөгөөд 7 дугаар сард +34°C байна. Гэхдээ зуны халуун өдөр хөрсний гадарга маш их халах тохиолдол байдаг. Хөрсний гадаргын жилийн үнэмлэхүй их температур 62°C. Хөрсний хөлдөлтийн хэм 0.8-1.8 м байдаг.

Цасан бүрхүүл, цастай өдрийн тоо

Цасан бүрхүүлийн зузаан дунджаар 2-3 см-ээс хэтэрдэггүй, цасан бүрхүүлийн үнэмлэхүй зузаан нь 16 см байдаг. Жилд цасан бүрхүүлтэй өдрийн тоо 33 байдаг бөгөөд хүйтний улиралд сард 1-3 удаа цас ордог байна. Цас орой унаж (12-р сарын сүүлч, 1-р сарын эхээр) хавар эрт (2-р сарын сүүлчээр) хайлна. Бороотой өдрийн тоо жилд дунджаар 22 байдаг.

3.2. Төслийн агаар орчинд нөлөөлөх байдал

Төслийн үйл ажиллагааны явцад агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөл нь тоосжилтын нөлөө байна. Тоосжилтын нөлөөллийн эрчим, хамрах хүрээг сансрын зурагт үндэслэн доор үзүүлэв.

Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилтын орон зайн тархалт

Нөлөөллийн эрчим	Их	Дунд	Бага	Нөлөөллийн бүс	Нөлөөллийн үргэлжилэх хугацаа
Эх үүсвэр					
Уурхайн малталт, хөрс ачих, тээвэрлэх, овоолох	Эх үүсвэрийн орчимд	50 м	150 м	150 м	Уурхайн ажиллах хугацаанд
Нүүрс хадгалах талбай	100 м	600 м	1400 м	1400 м	Уурхайн ажиллах хугацаанд
Нүүрс тээврийн зам болон бусад зам	Эх үүсвэрийн орчимд	50 м	100 м	100 м	Тээвэрлэлтийн үед
Энд:					
-Гол сөрөг нөлөөлөл					
-Болзошгүй сөрөг нөлөөлөл					

Хүснэгт.1 Тоосжилтын орон зайн тархалт

1 болон 3-р улиралын агаарын хяналт шинжилгээний үр дүнг харьцуулан үзэхэд 1-р улиралд улиралд уурхайн тоосжилт болон байгалийн хүчин зүйлээс хамааран нийт тоосжилтын хэмжээ зарим цэгүүдэд стандарт хэмжээнээс ихэссэн үзүүлэлттэй гарч байсан. Бусад улиралуудад стандарт хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт ажиглагдаагүй байгааг үр дүнгээс харж болохоор байна.

3.3. Төслийн гадаргын болон газрын доорхи усанд нөлөөлөх байдал

“Хүрэн шандын нүүрсний ордыг ашиглах” төслийн талбай нь Төв Азийн гадагшаа урсгалгүй ай савд багтана. Тухайн жил улирлын цаг уур, хур тунадасны хэмжээнээс хамаарч усны горим ихэд хувьсамтгай, заримдаа хуурай сайранд ширгэдэг. Их цас орж хайлах, үргэлжилсэн бороотой үед хэдэн арван км үргэлжилсэн хуурай сайрууд ширүүн урсгалтай гол болж заримдаа бүр БНХАУ-ын нутагт орших Гашуун нуур хүрнэ.

Нарийн сухайтын тохирол, хагарлын гарал үүсэлтэй олон тооны булгууд тохиолддог ба ихэнх нь мөн урагшаа урсгалтай бөгөөд элсэн доогуур шургахаас гадна Гашуун нуурын тэжээгдлийн эх үүсвэр болж байдаг. Хүн малын ундаанд худгийн ус хэрэглэх ба худгийн усны түвшин 1-2 м, заримдаа 5-7 м байдаг.

Хүрэншандын талбайд (ил уурхай) орж ирэх усны хэмжээг тодорхойлоход “энгийн” нөхцөлтэй ордын ангилалд орох боломжтой. Хүрэншандын хайгуулын талбайд дээд пермийн Дэлийншандын формацийн тунамал хурдас нь усжилт багатай бөгөөд уст үе, давхарга, ан цав-хагарлын нэгэн уст цогцолборыг бүрдүүлэх ба чөлөөт гадаргатай, даралтгүй устай юм. 2015 онд “Интернейшнл Майнинг

Консалтинг” ХХК-ийн гүйцэтгэсэн “Хүрэншандын нүүрсний ордын гидрогеологийн судалгааны” тайланд тусгагдсанаар уулын малталтын хананы ан цавын сүлжээний дагуу тодорхой хэсгүүдээс

газрын доорх усны урсац бага хэмжээгээр шүүрэх учраас уулын малталтын хананы нийт уртын дагуу ус шүүрэхгүй, уулын малталтын тодорхой нэгж талбайгаар шүүрч орж ирэх газрын доорх усны урсацын хэмжээ нь 26.64м³/хоног-оос хэтрэхгүй гэсэн дүгнэлт хийсэн. Мөн Уулын малталтанд орж ирэх хур тунадас (цасны шар ус, аадар бороо)-ны усны нийт хэмжээ 200 м³ гэж тооцсон.

Усанд нөлөөлөх нөлөөлөл

Эх үүсвэр	Нөлөөлөл		
	Эрчим	Хамрах хүрээ	Үргэлжилэх хугацаа
Гүний ус			
Шүүрлийн ус	Их	Уурхайн орчин	Төслийн үргэлжилэх хугацаанд
Цэвэрлэх байгууламж	Дунд	Ажилчдын суурин орчимд	
Энд:			
	-Гол сөрөг нөлөөлөл		
	-Болзошгүй сөрөг нөлөөлөл		

Хүснэгт.2 Усан орчны нөлөөлөл

3.4. Төслийн хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдал

Тус талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Говийн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн Говь-Алтайн хөрсний дэд бүсийн хүрээнд Алтайн чанад дахь хөрсний тойрогт хамаарагдана.

Хөрсний шинч чанарын үзүүлэлт:

Хөрсний нэр: Нөлөөлөлд өртсөн Гөлтгөнөт Бор саарал хөрс

Өмнөговь аймаг. Гурвантэс сум.

Газрын нэр: Уртын багын нутаг, Хүрэн шандын нүүрсний уурхайн зүүн, зүүн өмнөд хагаст, бага хэвгийтэй толгодорхог хэсэгт.

Огноо: 2015.12.19

Координат: Хойд өргөрөг (Y): 43,00627о Зүүн уртраг (X): 101,13722о

Газрын гадарга: Толгодорхог бэл, хажуу 1-3 хэм.

Ургамал: Сөөг-хармагт цөлийн хээр. Бүрхэц 10-15%.



Зураг.3 Хөрсний ерөнхий төлөв, босоо зүсэлт

Тоос. 0-1 см. Нүүрсний нарийн ширхэгтэй үе

Вт. 4-16 см. Бор улбардуу, өлөн чийгтэй (хөлдүү), сийрэгдүү, сайр чулуу 15%, ургамлын дутуу ялзарсан цөөн үндэстэй, бөөмөрхөг бүтэцтэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, карбонаттай, шилжилт өнгөөр тод.

Вт, са. 16-40 см. Улбардуу бор шаргал, өлөн чийгтэй (хөлдүү), нягтавттар, сайр чулуу 15%, үндэсгүй, бөөмөрхөг бүтэцтэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, карбонаттай, шилжилт өнгөөр тод, гөлтгөнөт үе.

Зүсэлтийн дугаар	Гүн, см	pH _{H2O} (1:2.5)	CaCO ₃ %	Ялзмаг %	EC _{2.5} dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
						P ₂ O ₅	K ₂ O
Зүсэлт-2	0-1	7.13	1.09	2.348	1.133	1.26	12.9
	1-14	7.34	4.24	0.796	5.620	0.97	8.1

	14-50	7.37	4.00	0.227	5.280	0.154	4.6
--	-------	------	------	-------	-------	-------	-----

Хүснэгт.3 Хөрсний үржил шимийн үзүүлэлт


Үржил шимийн үзүүлэлтүүдийн тайлбар: Вt давхарга нь 13 см зузаан, түүний доор орших Улбардуу бор өнгөтэй гөлтгөнөт хуримтлал бүхий Вt, са үе давхарга 36 орчим см зузаантай. Үржил шим бүхий үе давхаргын зузаан нь 50 см байна. Өнгөн Вt давхаргын хөрсний урвалын орчин рН-7.34, карбонат (CaCO_3 -4.24 %) илэрсэн, органикийн агууламж 0.726 %, цахилгаан дамжуулах чанар ЕС- 5.620 ds/m. Вt, са үе давхаргын хөрсний урвалын орчин рН-7.37 дээд үе давхаргаасаа илүү шүлтлэг, карбонат (CaCO_3 -4.00 %) дээд үе давхаргаас бага илэрсэн, органикийн агууламж 0.227 %, цахилгаан дамжуулах чанар ЕС- 5.28 ds/m. Ижил хэв шинжийн хөрсний үржил шимийн үзүүлэлттэй ойролцоо хэдий гадаргын өнгөн үед тоосон хуримтлал бүхий үелэл шинээр үүссэн байна. Энэ үеийн органикийн агууламж нь 2.348% буюу нөлөөлөлд өртөөгүй хөрсний үзүүлэлтээс 4-5 өндөр байна (Цөлийн Бор саарал хөрсний органикийн агууламж 0.2-0.5%. Доржготов, 2003). Харин доод үе давхаргуудын үржил шимийн үзүүлэлтүүд хэвийн хэмжээнд байна.

Үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвчид хэрхэн нөлөөлөх, нөлөөллүүдийг, сөрөг нөлөөллийг хэрхэн багасгаж болох арга замыг доор тусгалаа. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрсөн бүрхэвч сүйдэх, хүчтэй эвдрэнэ
- Нүүрс ачихаас үүдэлтэй тоосжилтын асуудал, мөн түүнчлэн машин техникийн хөдөлгөөнөөс үүдэлтэй тоосжилт бий болох.
- Уурхайн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн хөрс бохирдох
- Уурхайн үйл ажиллагаанд хэрэглэж буй төрөл бүрийн бүтээгдэхүүн (шатах тослох материал, нефтийн бүтээгдэхүүнүүд)-ий алдралаас үүдэн хөрс, хөрсөн бүрхэвч бохирдох
- Түр суурингийн бохир усны саванд ирж буй бохир усны хэмжээ багтаамжаас давж халих, гэмтэх зэргээс үүдэн бохир ус алдагдах , тэр нь орчны хөрсөн бүрхэвчид сөргөөр нөлөөлөх, хөрсийг бохирдуулах.
- Уурхайн үйл ажиллагаатай холбоотой бүх объектуудаас гарч хатуу хог хаягдалаар хөрс бохирдох, доройтох зэрэг болно.

3.5. Төслийн ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал

Хүрэншанд нүүрсний уурхайн хойд хэсэгт Сибирь хамраг, улаан бударгана зэрэг сөөг сөөгөнцөр ургамал зонхилох бөгөөд ургамлан бүрхэвчийн хувьд халцгай газар, чулуу ихтэй ба 25-35% нь ургамлан нөмрөгтэй байна. Мөн зарим бэл толгодын энгэрт гялгар дэрс, хармаг зонхилсон, тэгш газраар тэсэг-тогторгонот цөл тохионо. Нүүрсний уурхайн баруун болон урд хэсэг нам уулсын садарга, жалга орчмоор харгана, монгол бүйлээс, шар модон хотирт бүлгэмдэлтэй байна.



Зураг.4 Төслийн талбай орчмын ургамалжилт

Уурхайн ашиглалтын үндсэн процесст: *үржил шимт, өнгөн хөрс хуулалт, хөрс хуулалт, нүүрс олборлолт, гадаад овоолго тэгшилэлт, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил* зэрэг орно.

Одоогийн байдлаар ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн ихэнхи хэсэг төслийн үйл ажиллагаанд өртөн эвдэрсэн байна. Мөн төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх тоосжилтын нөлөөгөөр төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг доройтолд орох нөхцөл бүрдсэн байна.

Ургамлан нөмрөгт тоосны үзүүлэх нөлөөлөл нь эх үүсвэрээс 50-1500 м хүртэл байх боломжтой байна.

3.6. Төслийн амьтны аймагт нөлөөлөх байдал

Төсөл хэрэгжих орчинд уул уурхайн компаниуд олборлолтын үйл ажиллагаа явуулаад багагүй хугацаа өнгөрч байгаа бөгөөд тухайн бүс нутгийн боломжит амьдрах орчинд түшиглэн хийсэн судалгаагаар ховордлын зэрэг өндөртэй төрөл зүйлүүд байх боломжтой нь ажиглагдлаа. Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа, нүүрс тээврийн үйл ажиллагаатай холбоотойгоор биологийн төрөл зүйлүүдийн амьдрах орчинд нөлөөлөх, шилжилт хөдөлгөөн хязгаарлагдах зэрэг нөлөөллүүд үүсэх боломжтой юм.

3.7. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, цар хүрээ

Энд үзүүлсэн сөрөг нөлөөллүүдийн орон зайн давхцалуудыг тодорхойлон гол болон Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгүүд болзошгүй сөрөг нөлөөллүүдийг үнэлж тогтоон тэдгээрийн нөлөөллийн буурах зай, эрчимшлийг тодорхойллоо. Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг үр дагавар түүний нөлөөллийн буурах зай, эрчимшлийг тогтооход хээрийн судалгаа шинжилгээ, хэмжилтийн дүн болон зөвлөх судлаачдын туршлагаар тодорхойлж газарзүйн мэдээллийн систем дээр тулгуурласан “Нөлөөлөл орон зайд буурах функц” –ыг ашиглан зураглалаа.

Нөлөөлөл орон зайд буурах (Fi) функц

$$Fi = 1 + \exp(-Distance / 100 - a * b * Weight)$$

Үүнд:

$Distance$ - нөлөөлөл буурах зай,

Weight - нөлөөллийн эрчим

a, b - налуугийн хүчин зүйлс

Нөлөөлөл буурах зай болон нөлөөллийн эрчим зэрэг нь нөлөөллийн төрөл, газар орны нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байх тул нөлөөлөл буурах зэрэгтэй уялдуулан налуугийн хүчин зүйлсийг сонгож нөлөөлөл буурах функцыг тогтооно.

Төсөл нь хэрэгжиж эхлээгүй байгаагаас төслийн үйл ажиллагаа явуулах талбайд хийсэн хээрийн судалгааны үр дүнд үндэслэн тооцоолол хийх боломжгүй байсан тул ижил төстэй урьд өмнө хийгдэж байсан алтны шороон ордуудын үр дүнд шинжилгээ хийж төслийн нөлөөллийн тархах зай, эрчимшлийг дараах байдлаар тодорхойлсон.

Төслийн үйл ажиллагааны нөлөөнөөс үүсэх сөрөг нөлөөл нь экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгүүд болох хөрс, ургамлан бүрхэвчид голлон нөлөө үзүүлж эх үүсвэрээс хамраана хамрах хүрээ, орон зай, хил хязгаар нь өөр өөр байна. Ил уурхай, овоолгын ойролцоо газраар хөрсний эвдрэл хүчтэй явагдана.

Тооцоолол хийхдээ эх үүсвэрээс шалтгаалсан нөлөөллүүдийг дараахи Олон улсын The Nature Conservancy байгууллагын Монгол орны хэмжээнд хийсэн Экологийн бүс нутгийн үнэлгээний тайланд тулгуурлан бүтээсэн MDT /Mongolian Offset Design/ буюу Нөлөөлөл бууруулах загвар програм ашиглан тооцлоо.

НБЗП-Десктоп нь үндсэн дөрвөн багц програмтай:

1. Land Disturbance and Impact Tools-Нөлөөллийн эх үүсвэр болон Нөлөөллийн програм
2. Offset Tools- Дүйцүүлэн хамгааллын програм,
3. Supplementary Avoidance Tools-Нэмэлт Зайлсхийх програм,
4. Update Tools-Шинэчлэх програм.

Төсөл хэрэгжих үеийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	шууд	шууд бус	өөрөө зохицуулагдах	богино хугацааны	урт хугацааны	буцаж нөлөөлөх	буцалтгүй нөлөөлөх	хүчтэй	дунд зэрэг	бага зэрэг
Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт	x				x		x		x	
Газрын доорх усны чанарын өөрчлөлт	x				x		x		x	
Гадаргын усны урсацын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй									
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x		x				x	x		
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x	x		
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		x		x			x		x	
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x		x			x	x		
Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	x				x		x		x	

Бэлчээрийн байдал	x			x			x		x	
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x		x	
Эрчим хүчний нөөц	Нөлөөлөл байхгүй									
Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	x				x		x	x		
Агаарын бохирдол	x		x			x		x		
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x	x		
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		x			x	x				x
Дуу чимээ, шуугианы нөлөө	x			x			x		x	
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x	x		
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x	x		
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
Нийгэмд үзүүлэх нөлөө										
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		x		x			x			x
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх	x			x			x		x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x		x				x
Эди йн засаг, байгаль орчин										
Татварын орлого өөрчлөгдөх	x			x			x		x	
Бүс нутгийн орлого нэмэгдэх	x			x			x		x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x			x			x		x	
Ажлын байр нэмэгдэх	x			x			x		x	

Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x			x			x		x	
7. Бусад нөлөөлөл										
Уурхайн болон ахуйн бохир уснаас хөрс, ус бохирдох	x				x		x		x	
Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x	x		
Дүн	22	5	2	12	13	3	24	10	14	3

Хүснэгт. 4 Төслийн нөлөөллийн эрчим

Эдгээр болзошгүй нөлөөллүүдийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал:

Шууд нөлөөлөл

Болзошгүй нөлөөллийн 22 (81,5%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Нүүрсний орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл, бэлчээрийн

нөөц багасах, газрын доорх усны чанарт, геологийн тогтоц, ландшафтын хэлбэр, хүрээлэн буй орчин, тусгай хамгаалалттай газар нутаг зэрэгт сөргөөр нөлөөлж экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж болзошгүй байна.

Шууд бус нөлөөлөл

Уг төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 5 (18,5%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, Уур амьсгалын (бичил) өөрчлөлт, Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх, Үйлчилгээний салбар зэрэгт шууд бусаар нөлөөлөхөөр байна.

Өөрөө зохицуулагдах нөлөөлөл

Нүүрсний орд ашиглах төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 2 (7,4%) нь өөрөө зохицуулагдах нөлөөлөлд хамрагдаж байна.

Богино хугацааны нөлөөлөл

Уг төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 12 (44,4 %) нь богино хугацааны нөлөөлөлд орж байна. Богино хугацааны нөлөөлөлд зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, уур амьсгалын (бичил) өөрчлөлт, бэлчээрийн байдал зэрэг богино хугацаанд өөрөө зохицуулагдах нөлөөлөл гэж авч үзлээ.

Урт хугацааны нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн 13 (48,1%) нь урт хугацааны нөлөөлөл бөгөөд төслийн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийн ихэнхи нь урт хугацааны нөлөөлөлд хамрагдаж байна.

Нөлөөллийн эрчим

Төсөл хэрэгжих орчны байгаль орчинд тухайн төслөөс гарах хүчтэй нөлөөлөл их бөгөөд талбайн болон түүний орчны хөрс, ургамлын элэгдэл, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх, агаар, хөрс, усны бохирдол, ландшафтын хэлбэр өнгө өөрчлөгдөх зэрэг нөлөөллүүд байна. Дунд зэргийн эрчимтэй нөлөөлөлд газрын гадаргын нөөц баялаг, зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, татварын орлого, бүс нутгийн орлого нэмэгдэх зэрэг нөлөөллүүд багтана.

Бага зэргийн эрчимтэй нөлөөлөлд хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг нөлөөллүүд багтаж байна. Нийт 27 нөлөөллөөс 10 хүчтэй, 14 дунд зэргийн, 3 бага зэргийн нөлөөлөл байна.

4.ХҮРЭНШАНДЫН УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Өсөх зоос” ХХК нь 2010 онд 15177Х тоот тусгай зөвшөөрөл бүхий Хүрэншанд талбайд хайгуулын ажлыг гүйцэтгэж ордын нөөцийг 2012 оны 10-р сарын 19 -нд Монгол улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн ба Кадастрын хэлтсийн даргын 2013 оны 05 дугаар сарын 27–ний 229 тоот шийдвэрээр MV-017317 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 30 жилийн хугацаатайгаар авсан.

2014 оноос эхлэн нүүрсний ордод үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба 2014-2019 оны хооронд анх батлагдсан нөөцөөс 14.64 сая.тн нүүрсийг олборлосон байдаг. Улмаар 2020 онд 2014-2017 оны хооронд хийсэн нэмэлт хайгуулын алжын үр дүнд тулгуурлан үлдэгдэл нөөцийг шинэчлэн тооцож ордын нөөцийг 2020 оны 1 сарын 1-ний байдлаар ордын нөөцийг 79.6 сая.тн-оор батлуулсан. Шинэчлэсэн нөөц батлагдсанаас хойш 2020, 2021 онд нийт 3.76 сая.тн нөөц олборлож 2021 оны 11 сарын 16-ны байдлаар 75.84 сая.тн нүүрсний нөөцийн үлдэгдэлтэй байна.

Хүрэншандын уурхайн нийт урт 1.18 км, өргөн нь 1.02 км, уурхайн гүн 167 м, уурхайн хананы ерөнхий налуу хамгийн багадаа 25°, нүүрсний давхаргуудын гарш хэсэгт байрлана. Баруун талаараа хайгуулын I-I’ шугамаар, зүүн талаараа лицензийн зүүн хил урд талаараа хайгуулын Д-Д’ шугам хойд талаараа нүүрсний V давхаргын гаршаар хязгаарлагдана.Хүрэншандын уурхай нь жилд 2.5 сая.т нүүрс олборлох төслийн хүчин чадалтай байна.

Ил уурхай нь жилд ажиллах хоногийг 350 хоногоор, хоногт 2 ээлжээр, ээлжинд 12 цаг ажиллахаар төлөвлөсөн байна.



Зураг 5 Хүрэншандын уурхай

Уурхайн барилга байгууламж

Хүрэншанд нүүрсний уурхайн хотхоныг ил уурхайн талбайгаас баруун тийш 3 км орчим зайд байрлуулсан байна. Төсөл хэрэгжүүлэгч нь Хүрэншанд төслийн үйл ажиллагааг 2014 онд эхэлсэн бөгөөд уурхайн кэмп болон бусад объектыг түр байгууламжаар шийдвэрлэсэн байна.

Төслийн хүрээнд Хүрэншандын хэсэгт олборлолт явуулах үед ажиллах хүчний хэрэгцээнд тулгуурлан 2018 оны 8-р сарын 28-нд нийт 480 хүний багтаамж бүхий уурхайн тосгоныг ашиглалтанд оруулсан ба уурхайн хойд хэсэгт шинээр оффисын барилгыг ашиглалтанд оруулаад байна.

Эрчим хүч цахилгаан хангамж

Хүрэншандын нүүрсний уурхайн цахилгааны гол хэрэглэгчид нь ил уурхай, засварын цех, лаборатори, уурхайн кэмп ба эдгээр хэсгүүдэд шаардлагатай цахилгааныг “Нарийн сухайт эрчим” ХХК-ны 35Кв-н Дэд станцаас 10Кв-н ЦДАШ-аар дамжуулан цахилгааны эх үүсвэрээ хангаж байна.



Зураг 5,6 Уурхайн ажилчдын хотхон, Засвар үйлчилгээний төв



Зураг 7 Гаалийн хяналтын талбай



Зураг 8 Цахилгаан дамжуулах агаарын шугам

Ус дулаан хангамж

Хүрэншандын нүүрсний уурхай нь Алтайн Өвөр Говь сав газарт багтах ба усны найрлагаас шалтгаалан ажилчдын ундны усны хэрэгцээг Өмнөговь аймгаас тээвэрлэн нийлүүлдэг савласан усаар хангадаг. Ахуйн хэрэглээний усыг тусгай зөвшөөрөл бүхий гүний цооногуудаас шахуурга ашиглан хэрэглэж байна. Уурхайн тоос дарах, нөхөн сэргээлтийн усалгааны зориулалтаар цөөрөмд цуглуулсан хур борооны болон уурхайн шүүрлийн усыг ашиглаж байна.


Уурхайн ажилчдын тосгон, засвар үйлчилгээний төвийн унд ахуйн усны хэрэглээг нийт 3 гүний худагаас хангаж байна. Доорх хүснэгтэд гүний хүдгийн техникийн үзүүлэлтийг харууллаа.



Зураг 8 Ус хангамжийн худгууд



Зураг 9 хаягдал почка хадгалах талбай



Зураг 10 Хаягдал дугуйн талбай



Зураг 11 Хог хаягдал ангилах анхан шатны цэг
цэг



Зураг 12 Хуванцар сав ангилан хуримтлуулах

5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ

2024оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тооцох, бууруулах, түүнд шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, хэрэгжүүлэх үе шат зэргийг нарийвчлан тусгах эрх зүйн бичиг баримт болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан арга хэмжээнүүдийг шат дараатай төлөвлөж хэрэгжүүлэх, төслийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт хийгдэх ажил, холбогдох төрийн байгууллага, сум орон нутгийн оролцогч талуудын санал дүгнэлтэнд үндэслэн боловсруулах зорилго тавив. Байгаль орчны, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот дугаар тушаал “БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ”, “Байгаль орчныг хамгаалах тухай” “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан зэргийг удирдлага болгож боловсруулав.

Бид дараах ажлуудаар тогтвортой хөгжлийн баталгаа болгож байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг боломжит хамгийн бага хэмжээнд хүргэх зорилт тавьж байна. Үүнд:

- Байгаль орчны бүх хууль, тогтоомжуудыг мөрдөж ажиллах
- Байгаль орчныг хамгаалах шилдэг аргуудыг үйл ажиллагаандаа бий болгох удирдлагын системийг хэрэгжүүлэх.
- Бүхий л үйл ажиллагаандаа "багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах" зарчмыг хэрэгжүүлэх.
- Ажилчдад байгаль орчноо хамгаалах хариуцлага, танин мэдэхүйг дээшлүүлэх, төслийн талбайд мөрдөгддөг дүрэм журмыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд сургалтанд хамруулах.
- Байгаль орчныг хамгаалах өөрсдийн үүрэг хариуцлагаа ухамсарлаж, үйлчлүүлэгч болон ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллах.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах ажлын төлөвлөлт хэрэгжилтийг тогтмол сайжруулах.
- Ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжийн хүрээнд мөрдөгддөг хууль тогтоомжыг хэрэгжүүлэх.
- Компанийн дотоод дүрэм, журам, горимд байгаль орчныг хамгаалах зорилгыг хэрэгжүүлэх заалтуудыг нэмэгдүүлэх.
- Нийт ажиллагсад, гэрээт олборлогч, ажилчид, ханган нийлүүлэгчид, сонирхогч талуудад байгаль орчны баримтлах бодлого, зорилгыг таниулах, уурхайд мөрдөх дүрэм журмуудыг мөрдүүлэх.

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас агаар дахь тоосжилт нэмэгдэх.	Нүүрс тээврийн болон уурхайн дотор тээврийн зам зэрэгт арчилгаа усалгааг тогтмол хийх, уурхайн хөрс орчинд тохирсон тоосжилт бууруулах бодис турших.	Уурхайн ашиглалтын талбай	км	Дотоод зардал	1 удаа	Дотоод зардал	Тогтмол	Агаарын тухай хууль, Агаарын чанарын ерөнхий шаардлага MNS 5365:2004 MNS6734:2018
2	Цацраг идэвхит бодисыг	Цацрагийн шинжилгээ хийлгэх ЗДХ-ээс хэтэрсэн тохиолдолд бууруулах арга хэмжээ авах		удаа	-	1	Дотоод зардал	Тухайн жилдээ	
3	Агаарын бохирдлыг бууруулах.	Гурвантэс суманд утаагүй Нүүдэлчин зуухыг төсөл хэрэгжүүлэх	Гурвантэс сум Бага овоо баг	ш	10,000,000	10-15	10,000,000	Тухайн жилдээ	
НИЙТ ЗАРДАЛ							10,000,000		

6.2 Усны нөөц болон чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гадаргын болон газрын доорх усны нөөц хомсдох, хог хаягдал хүний үйл ажиллагааны улмаас эх үүсвэр бохирдох	Хөвдийн булгийн эхийн хашиж хамгаалсан ажлыг мэргэжлийн байгууллагаар зураг хийлгэн сайжруулах, тохижуулах.	Уурхайн нөлөөллийн бүс, Бага овоо баг	ш	10,000,000	1	10,000,000	1 удаа	Усны тухай хууль, Ундны усны эрүүл ахуйн шаардлага,

2		Уурхайн бохир цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, саарал усыг эргүүлэн ашиглах.		ш	Үйл ажиллагааны зардал			-	чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900-2018, Бусад дүрэм журам.
3		Дэлхийн усны өдрийг Сум орон нутагтай хамтран тэмдэглэх, зохион байгуулах		ш	500,000	1	500,000	Жилд нэг удаа	
4	Усны зохисгүй хэрэглээ бий болох усны тухай хууль зөрчигдөх	Ус ашиглалт, зарцуулалттай холбоотой бичиг баримтын бүрдлийг хангах.	Хүрэншанд уурхай	тогтмол	500,000	-	500,000	тухай бүр	
НИЙТ ЗАРДАЛ							11,000,000		

6.3 Хөрс хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Өнгөн хөрс элэгдэх доройтох	Шинээр газар хөндөх тохиолдолд шимт болон шимэрхэг хөрсийг хуулах, хуулсан хөрсийг стандартын дагуу хадгалах, хамгаалах.	Уурхайн бүс	Тухай бүр	-	-	-	Жилийн турш	Хүрэншанд уурхай өнгөн хөрс хуулах, хадгалах, хамгаалах журам айгаль орчин.
2	Машин механизмаас үүсэх асгаралтаас хөрс бохирдох.	Засвар үйлчилгээний явцад үүсэх асгаралтыг бууруулах бохирдсон хөрсийг саармагжуулах журам, зааварчилгааг мөрдөж ажиллах.	Уурхайн бүс	тогтмол	1,000,000	тогтмол	1,000,000	Жилийн турш	MNS5916:2008 Газар шорооны ажлын үед үржил

		засвар үйлчилгээнээс үүссэн ажилласан тос маслыг хуримтлуулах савыг шинэчлэх							шимт хөрс хуулалт, хадгалалт
3		Шороон замын сүлжээг багасгах зорилгоор сайжруулсан шороон зам тавих ажлыг Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулдаг уурхайнуудтай хамтран зохион байгуулах.	Бага овоо баг	удаа	Үйл ажиллагааны зардал	1	Үйл ажиллагааны зардал	2, 3-р улиралд	
НИЙТ ЗАРДАЛ								1,000,000	

6.4 Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Газрын гадарга доройтох эвдрэлд өртөх	Үйл ажиллагааны явцад аливаа газар шорооны /инженерийн/ ажил уурхайн ахилт зэрэг газар ашиглалттай холбоотой арга хэмжээний үед газар хөндөх зөвшөөрлийг маягтын дагуу бүртгүүлэн хөндөх.	Уурхайн бүс	Инженерийн ажлын тоо	Үйл ажиллагааны зардал	Газар хөндөх бүртгэлийн тоо	Үйл ажиллагааны зардал	Тогтмол	Газрын хэвлийн тухай хууль, Шимт хөрс хуулах хадгалах журам стандарт
2		Газрын хэвлийн тухай хуулийн дагуу уулын ажлын	Уурхайн үйл ажиллагаа	Уурхайн ахилт хийгдсэн	Үйл ажиллагааны зардал	-	Үйл ажиллагааны зардал	Тогтмол	

		төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах.		талбайн хэмжээ					
НИЙТ ЗАРДАЛ							-		

6.5 Ургамлын зүйлийн бүрдэл ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ургамлан бүрхэвч доройтох, зүйлийн бүрдэл хомсдох	Уурхайн бүсэд ургамлын төрөл зүйлийн судалгааг уурхайн нөлөөлөл болон нөлөөллийн бус 9-10 цэгийг хамруулан хийн геоботаникийн бичиглэл хийх	Уурхайн бүс	Ажиглалтын тоо	-	Зудаа	-	6-8-р сард	Ургамал хамгаалах тухай хууль Газрын хэвлийн тухай хууль
2		Нутгийн эндемик зүйлийн ургамлын биомассыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Хөвд орчимд жигд тарих, хашиж хамгаалах	Гурвантэс сум	ш	10,000,000	500	10,000,000	Тухайн жилдээ	
НИЙТ ЗАРДАЛ								10,000,000	

6.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн олборлолт, барилга байгууламж баригдах явцад дуу чимээ, тээврийн хөдөлгөөний улмаас амьдрах орчны шууд хомсдол үүсэх.	Цаг агаарын нөхцөл байдлаас хамаарсан идэш тэжээлийн хомсдол үүсэхээс сэргийлэх биотехникийн арга хэмжээг Уурхайн бүс болон бусад газруудад	Гурвантэс сум	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	2-3	5,000,000	Тухайн жилдээ	Ан амьтан хамгаалах тухай хууль
2		Уурхайн бүсийн дэд бүтэц цахилгааны шугамаас шалтгаалсан шувуудын үхэл хоргодолоос сэргийлэх. Үзлэг шалгалтыг хийх.	Уурхайн бүс	Ажиглалтын тоо	500,000	Бүртгэл тайлангийн тоо	-	Сард 1 удаа	
3		Хүрээлэн буй орчин гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран ажиллах.	Гурвантэс сум	удаа	Дотоод зардал		Дотоод зардал	Тухайн жилдээ	
НИЙТ ЗАРДАЛ							5,000,000		

7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /ТЕХНИКИЙН, БИОЛОГИЙН/

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Техникийн нөхөн сэргээлт	“Нарийнсухайт-Гурвантэс” орох олон салаа замын ноогдсон талбайд нөхөн сэргээлт хийх	га	6	Үйл ажиллагааны зардал		2, 3-р улирал	Уул уурхайн эвдрэлд орсон газарт техникийн болон
2		Уурхайн үйл ажиллагааны явцад ашиглалт дууссан талбай гарсан тохиолдолд нөхөн сэргээлт хийх	га	-	Үйл ажиллагааны зардал		Тухай бүр	биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал,
3	Биологийн нөхөн сэргээлт	Тоорой модны судалгаа хийхэд нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах зулзаган тоорой бүхий талбайг хашиж хамгаалах ажилд дэмжлэг үзүүлэх	га	-		10,000,000	2,3-р улирал	Нөхөн сэргээлт хийх журам зааварчилгаа.
Нийт						10,000,000		

8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Нутгийн унаган ургамлан нөмрөгийг нэмэгдүүлэх, хамгаалах,	Заган ойг үрээр болон тарьцаар нэмэгдүүлэх, хаших хамгаалах	Гурвантэс сум	5000	Дотоод зардал		Тухайн жилд	2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 374 дүгээр тогтоол, БОНБНУ-ний тухай хууль,
2	Өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний тасралтгүй үр ашигтай байдлыг дэмжих	Тост тосонбумбын нурууны эмийн ургамлын зурагт лавлахыг дахин хэвлүүлэх.	Гурвантэс сум	300	5,000,000		Тухайн жилд	
3		ТХГН хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах.	Гурвантэс сум	-	Дотоод зардал		Тухайн жилд	
НИЙТ ЗАРДАЛ					5,000,000			

9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Нөлөөллийн бүсийн 2 малчин өрх	Нөлөөллийг судлах, судалгааны үндсэн дээр шаардлагатай арга хэмжээг авах, хэрэгжүүлэх	Нөлөөллийн бүс	2	Үйл ажиллагааны зардал		1 удаа	
2	НИЙТ				-			

10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Соёлын биет бус өвийг дэмжих, дэлгэрүүлэх	Шагайн харваачдын холбоог дэмжих, хамтран ажиллах.	Гурвантэс сум Шагай харвааны холбоо	-	Үйл ажиллагааны	-	Жилд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
НИЙТ ЗАРДАЛ				-				

11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Байгалийн гамшигт үзэгдэл	Гамшигаас хамгаалах төлөвлөгөөг ОБГ-р батлуулж мөрдөх	Уурхайн бүсэд ажиллаж буй нийт ажилчид	Тодорхойлох боломжгүй	ХАБЭА-н үйл ажиллганы зардал		Тухайн жилдээ	Гамшгийн тухай хууль, ХАБЭА-н дүрэм журам, зааварчилгаа, хөдөлмөрийн нөхцөлийн үлэгээний журам.
2		Цаг агаарын урьдчилсан мэдээг дамжуулах, хүчтэй салхи, орон шуурганы мэдээлэл хурдыг цаг тухайд нь авч мэдээллэх	Уурхайн бүсэд явагдах бүх үйл ажиллагааны хэмжээнд	Мэдээллэсэн тоо, аюултай үзэгдлийн давтамж	-	-	Тухайн жилдээ	
3	Гал түймрийн аюул	Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан мөрдөж ажиллах	Уурхайн талбай	-	ХАБ-ын үйл ажиллагааны зардал		тогтмол	
4	НИЙТ				-			

12.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	Хог хаягдалтай холбоотой гэрээ, зөвшөөрөл, болон бусад бичиг баримт бүрдүүлэх.	Төслийн бүс	-	Дотоод зардал	-	Дотоод зардал	Тухайн жилдээ	Хог хаягдлын тухай хууль, Аюултай хог хаягдлын тухай хууль, Хог хаягдлын тухай журам
2		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хог хаягдлыг бууруулах, ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.		ТОГТМОЛ	-	-	-	Тухайн жилдээ	
3		Ахуйн болон аюултай хог хаягдал шатаах зуухыг шинэчлэх		ш	Дотоод зардал	1	Дотоод зардал	Тухайн жилдээ	
4		Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах үйлдвэр, компаниудтай хамтран ажиллах, хаягдлын хэмжээг бууруулах цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;		-	Дотоод зардал	Хийгдсэн гэрээгээр	Дотоод зардал	Тухайн жилдээ	
5	Аюултай хог хаягдал	Засвар үйлчилгээний явцад үүссэн хаягдал тосыг түр нөөцлөх саванд нийлүүлэхэд асгарахаас сэргийлэх, тос соруулах помп авч ашиглах		Удаа	2,000,000	1	2,000,000	Тухайн жилдээ	



6		Хог хаягдал гаргасны төлбөр болон бусад шаардлагатай мэдээг эрх бүхий байгууллагад гарган мэдээллэх.		ТОГТМОЛ	Дотоод зардал	-	Дотоод зардал	Тухайн жилдээ	
НИЙТ ЗАРДАЛ					2,000,000				

13.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
1	Агаар дахь нийт тоосны хэмжээ	- Ажилчдын хотхон - ШТС орчим - Засварын төв - Хаягдал хөрсний овоолго - Уурхайн карьер - Нүүрс тээврийн зам - Малчин өрх - Нүүрс ачилтын талбай	Жилд	2 удаа	280,000	560,000	ISO/MNS 17025:2018 стандартаар итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээг гүйцэтгүүлэх	MNS4585:2016
2	Гадаад орчны агаарт дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл				420,000	840,000		
3	Ундны ус болон цэвэрлэх байгууламжын усны бактериологийн шинжилгээ	- Цэвэрлэх байгууламжын гаралтын хэсэг - Ундны усны нэгдсэн шугам	Жилд	2 удаа	180,000	360,000		
4	Усны чанар гидрохимийн шинжилгээ	- Шүүрлийн ус хуримтлуулах зумп - Ажилдчын хотхоны 2 худаг - Хооллох заалны гал тогоо - Малчны худаг	Жилд	2 удаа	300,000	600,000		
5	Хөрсний чанар, агрохимийн шинжилгээ	Засварын төв Шимт хөрсний овоолго 1,4 Малчны хот Ажилчдын хотхон	Жилд	2 удаа	560,000	1,120,000		



6	Хөрсөнд агуулагдах хүнд металл хэмжээг тодорхойлох	- Засварын төв - ШТС-орчим - Хогийн цэг - Малчны хотхон - Ажилчдын хотхон	Жилд	2 удаа	500,000	1,000,000	ISO/MNS 17025:2018 стандартаар итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээг гүйцэтгүүлэх	MNS 5850:2019
7	Газрын тосны бүтээгдэхүүн	- ШТС орчим - Засварын төв	Жилд	2 удаа	200,000	400,000		MNS6838:2020
8	Агаарын нарийн ширхэгт тоосны хэмжилт хийж үр дүнг нэгтгэх.		Сард 1 удаа	-	-	Дотоод хяналт мониторинг		
9	Усны чанарын анхдагч үзүүлэлтийг хэмжих үр дүнг нэгтгэх. /рН,ЕС , температур/		Сард 1 удаа	-	-	Дотоод хяналт мониторинг		
10	Хаягдал бохир усны дүгнэлт ус бохирдуулсан төлбөр төлөх тухай гэрээний дагуу улирал бүр хаягдал бохир усны шинжилгээг хийлгэн Усны газарт хүргүүлэх.		Улирал тутам	4	60,000	240,000		
НИЙТ ЗАРДАЛ						5,120,000		

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			сар	сар	сар		
1	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулсан арга хэмжээг Гурвантэс сумын төрийн байгууллага болон Нарийнсухайтын бүлэг ордод үйл ажиллагаа явуулж буй уурхайнуудтай хамтран зохион байгуулах.	5,000,000	Тухайн жилд			Уурхайн удирдлага, Байгаль орчны мэргэжилтэнүүд Мэргэжлийн байгууллага Гурвантэс сумын ЗДТГ	- Цөлжилттэй тэмцэх өдөр - Дэлхийн усны өдөр - Биологийн олон янз байдлыг хамгаалах өдрүүдийг тохиолдуулан зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
2	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймаг Гурвантэс сум Өмнөговь аймаг Хүрмэн сум заг тарих Сэлэнгэ аймагт доройтсон ойн нөхөн сэргээлт хийх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.	Дотоод төсөв	Тухайн жилд				Хуршуутын голд хашаажуулсан талбайд тарилтын ажыг үргэлжлүүлэн хийх. Мөн Гурвантэс сумын төвд 5 га талбайд тарилтын ажлыг үргэлжлүүлэн хийх. Нийт 500,000ш мод тарих.
3	Уурхайн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх өдөрт 80м3 хүчин чадал бүхий байгууламж хийх.	Дотоод төсөв	Тухайн жилд			Байгаль орчны мэргэжилтэн, Сангийн инженер	Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS4943:2015 стандартын хүлцэх дээд агууламжид нийцүүлэн цэвэршүүлэх.
4	Нийт ажилчдад БО-ы чиглэлээр сургалт зохион байгуулах	Дотоод төсөв	Тухайн жилд			Байгаль орчны мэргэжилтэн	Нийт ажилчдад БО-ны хамгаалах талаар, Уурхайн бүсд мөрдөх дүрэм, журам бусад сургалтыг нийт ажилчид болон шинээр ирсэн ажилчдад орох.
	Нийт	5,000,000					

**15.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Нөлөөллийн бүсийн иргэд, багийн иргэдэд байгаль хамгаалах чиглэлээр хийгдэж буй ажлын тайлан танилцуулах	Илтгэл хэлэлцүүлэг	БО-ны чиглэлээр хийгдэж буй ажлууд	Зохион байгуулагдахаар товлосон хугацаанд	-	Байгаль орчны мэргэжилтэн	Багийн төв
2	2024 оны тайлангийн биелэлтийг танилцуулах	Хэвэлмэл тайлан, илтгэл	Тухайн жилийн БОМТөлөвлөгөөний биелэлтийг тайлагнах		-	Байгаль орчны мэргэжилтэн	Хүрэшанд уурхай
3	Ус ашиглалт, төлбөр төлөлтын талаарх мэдээ тайлан	Цахим болон Хэвэлмэл тайлан	Ус ашиглалт, түүнтэй холбоотой мэдээллийг холбогдох төрийн байгууллагад танилцуулах	Жилд 2	-		-
Нийт					-		

**16.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН
НЭГДСЭН ДҮН**

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Зардлын дүн /төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	37,000,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10,000,000
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,000,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	5,120,000
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	5,000,000
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	-
Нийт зардал /төг/		64,120,000